

СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСЫН БАКАЛАВРЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

I. Тавигдах шаардлага

1. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах жилдээ ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангид суралцаж буй Монгол Улсын иргэн байх, 80 ба түүнээс дээш дүнгийн хуулбартай байх ёстой.
2. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн нэгдүгээр дамжааны оюутан Монгол Улсын иргэн байх, 3.0 ба түүнээс дээш дүнгийн голч оноотой байх ёстой.
3. Өөр улсын засгийн газрын тэтгэлэгт хамрагдах боломжгүй байх

II. Мэргэжлийн сургалтын чиглэл, тэтгэлгийн тоо

- Олон улсын харилцаа
- Аялал жуулчлал
- Хүнсний инженерчлэл
- Анагаах ухаан
- Соёлын өвийг сэргээн засварлах
- Усны нөөцийн менежмент
- Сэргээгдэх эрчим хүч

Эдгээр мэргэжлүүд нь ажлын шаардлагаас хамааран өөрчлөгдөх магадлалтай бөгөөд жил бүр өөр өөр байж болно. Түүнчлэн тэтгэлэгт хөтөлбөрт элсэгчдийн тоо жил бүр тэтгэлгийн тоонд харилцан адилгүй байдаг.

III. Бүртгэл: Жил бүрийн 3-4-р сард явагддаг

<https://scholarship.esis.edu.mn/> хаягаар орж хэрэглэгчийн бүртгэл үүсгэн, онлайн анкет бөглөх ба илгээх гарын авлагыг уншиж, өргөдлөө илгээнэ.

Өргөдөлд дурдсан дараах баримт бичиг бүрийг "Баримт бичиг" хэсэгт PDF форматаар хавсаргана (1 файлын хэмжээ 5Mb-ээс хэтрэхгүй байх ёстой).

Цахим бүртгэлийн системд байршуулах бичиг баримт:

Ахлах сургуулийн төгсөгч бол:

- Цахим өргөдөл
- Ангийн багшийн зөвлөмжийн захидал;
- Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад засгийн газрын тэтгэлгээр суралцах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн захидал (монгол хэл дээр 500 гаруй үгтэй);
- 11-р ангийн дүнгийн дүнгийн хуулбар;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Сүүлийн 6 сарын хугацаанд авсан 3*4 хэмжээтэй зургийг цахим хэлбэрээр ирүүлнэ;

Бүртгэл хаагдах үед систем ачаалал ихтэй байдаг тул эрт бүртгүүлэхийг зөвлөж байна.

Хоцорсон иргэдийг нэмж бүртгэх боломжгүй тул заасан хугацаанд бүртгүүлнэ үү.

Цахим бүртгэлийн системд жинхэнэ, зөв баримт бичгийг байршуулах шаардлагатай. Хуурамчаар үйлдсэн тохиолдолд тэтгэлгийг цуцална.

IV. Сонгон шалгаруулалт

Сонгон шалгаруулалт нь хоёр үе шаттай явагдана.

- Бичиг баримтын эмхтгэл. Тэтгэлэгт хөтөлбөр нь өргөдөл гаргагчийн өргөдөл, эсээний агуулга, хамаарал, өөрийгөө илэрхийлэх чадварыг үнэлнэ.
- Ярилцлага. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулах юм. Цахим ярилцлагын хуваарь болон оролцогчдын жагсаалтыг БШУЯ-ны цахим хуудсанд байршуулна.

Бүх оролцогчдыг өргөдөл, ярилцлагын нийлбэр оноогоор эрэмбэлж, хамгийн өндөр оноо авсан хүмүүст тэтгэлэг олгоно.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ